



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/63

Арвайхээр

Буцалтгүй тусламж олгох тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2018 оны а/676 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсч өргөдөл ирүүлсэн Арвайхээр сумын 2 дугаар багийн иргэн н.Мөнгөнзоригийн охин Б.Хулан нь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа тул эм, тариа, эмчилгээнд нь зориулж 300000 (гурван зуун мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгосугай.

2. Дээрх иргэнд олгох 300000 (гурван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100135